

**Аймгийн улсын бүртгэл, статистикийн газар**

**Архангай аймгийн ХАА-н салбарын  
2015 оны танилцуулга**

**Цэцэрлэг хот**

## АГУУЛГА

### Оршил

#### I.Эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь

#### II. Мал аж ахуй

II.1. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлт

II.2. Малын 2015 оны тооллогын дүн

II.2.1. Малтай болон малчин өрх, малчид,  
тэдгээрийн соёл ахуйн үзүүлэлтүүд

II.2.2. Мал, тэжээвэр амьтдын тоо, сүргийн бүтэц

Малтай өрхийн бүлэглэлт  
Малчин өрхийн бүлэглэлт  
Хээлтэгч малын тоо  
Төл бойжилт  
Малын зүй бус хорогдол  
Хээл хаялт, сувайралт  
Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо  
Малын хэрэглээний зарлага  
Сүргийн бүтэц  
Сарлагын тоо

II.2.3. Үүлдрийн болон шилдэг омгийн мал

II.2.4. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

II.2.5. Тэжээвэр амьтад

II.2.6. Худаг, малын хашааны тоо, багтаамж

II.2.7. ХАА-д ажиллаж байгаа мэргэжилтэй боловсон хүчин

II.2.8. ХАА-д ашиглагдаж байгаа машин техникийн тоо

II.2.9. Малжуулах арга хэмжээний талаарх мэдээлэл

II.2.10. Шинээр гаргасан, засварласан худаг

II.3. Мал эмнэлгийн үйлчилгээ

II.4. Багуудын малын тоо толгой

II.4. Улсын малын тоо толгой

#### III. Газар тариалан

III.1. Тариалсан талбай

III.2. Газар тариалангийн үйлдвэрлэл, хураасан ургац

III.3. Га-гийн ургац

III.4. Хөдөө аж ахуйн эдэлбэр газар

### Дүгнэлт

#### Хавсралтууд

## НЭР ТОМЬЕОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

**Малтай өрх.** Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

**Малчин өрх.** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

**Малчид.** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

### **Бодод шилжүүлэх коэффициент:**

1 адуу, үхэр	- 1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

### **Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:**

1 тэмээ	- 5 хонь
1 адуу	- 7 хонь
1 үхэр	- 6 хонь
1 хонь	- 1 хонь
1 ямаа	- 0.9 хонь

Бодод шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

**Нас гүйцсэн мал.** Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

### **Өсвөр насны мал**

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай

Адуу- Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

**Төл мал.** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч.** Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

**Малын тоо, толгойн өсөлт.** Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

**Төллөлтийн хувь.** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

**Бойжилтын хувь.** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

**100 эхээс бойжуулсан төл.** Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

## **1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:**

Буур -	20-25
Азарга -	12-15
Бух -	35-45
Хуц, ухна -	25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

**Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь.** Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

### **Малын хэрэглээний зарлага.**

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

**Малын хашааны хангамж.** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

**Тэжээл хангамж.** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент.** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс	-	0.45
Таримал тэжээл	-	0.35
Даршны ургамал	-	0.25
Гар тэжээл, хужир шүү	-	1.00
Төмс ногооны хаягдал	-	0.22
Үр тарианы хаягдал	-	0.90
Лай	-	0.40
Сүрэл	-	0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

**Малын тэжээлийн ангилал.** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
  1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
  2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
  3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

**Тариалангийн талбай** . Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

**Тариалсан талбай.** Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

**Хураасан талбай.** Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

**Га-гийн ургац.** Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

**Нийт ургац.** Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

## ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2014 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Статистикийн хэлтсээс мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2013 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Малын 2015 оны тооллогыг уламжлалт 4 маягт, зааврын дагуу явуулж, өрх нэг бүрээр онлайнд шивж үр дүнг нэгтгэн гаргалаа.

Энэхүү танилцуулгад малын 2015 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, мал эмнэлгийн арга хэмжээ, шинээр гаргасан, сэргээн засварласан худаг, уст цэгийн талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Танилцуулгыг сумдаар болон аймгийн дүнгээр зэрэгцүүлэлт хийж харуулав.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж,цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.


### **I. Эдийн засагт мал аж ахуйн салбарын эзлэх байр суурь**

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас ихээхэн хамааралтай бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэлийг явуулахад гол түүхий эд болдог онцлогтой.

2015 оны байдлаар манай аймгийн ДНБ (Дотоодын нийт бүтээгдэхүүн)-ий урьдчилсан байдлаар 72.3 орчим хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж, ажиллах хүчний 65.7 хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Зураг 1

ДНБ-д ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

## **II. МАЛ АЖ АХУЙ**

### **II.1 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт**

Үйлдвэрлэсэн нийт бүтээгдхүүний 16.0 хувийг малын өсөлт үржилтийн бүтээгдхүүн, 34.2 хувийг мах, 47.3 хувийг сүү, 1.8 хувийг ноос,ноолуур, 0.4 хувийг арьс,шир , 0.3 хувийг бусад бүтээгдхүүний үйлдвэрлэл эзэлж байна.

Хүснэгт 1

Мал аж ахуйн бүтээгдхүүний үйлдвэрлэлт

	биет хэмжээ		Дүнд эзлэх хувь		2015/2014	
	2014	2015	2014	2015	хувь	зөрүү
<b>Мах мян,тн</b>	<b>42815.0</b>	<b>84873.1</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>198.2</b>	<b>42058.1</b>
Тэмээний	42.0	114.0	0.1	0.1	271.4	72.0
Адууны	4835.2	13101.7	11.3	15.4	271.0	8266.5
Үхрийн	10917.6	28412.7	25.5	33.5	260.2	17495.1
Хонины	17466.6	29164	40.8	34.4	167.0	11697.4
Ямааны	9553.7	14080.7	22.3	16.6	147.4	4527.0
<b>Сүү,мян,тн</b>	<b>65557.1</b>	<b>87658.2</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>133.7</b>	<b>22101.1</b>
Ингэний	16.8	55.0	0.03	0.1	327.4	38.2
Гүүний	5268.0	7791.1	8.0	8.9	147.9	2523.1
Үнээний	53438.5	69116.8	81.5	78.8	129.3	15678.3
Хонины	2731.9	5555.7	4.2	6.3	203.4	2823.8
Ямааны	4101.9	5139.6	6.3	5.9	125.3	1037.7
<b>Ноос,ноолуур, тн</b>	<b>3277.7</b>	<b>3891.3</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>118.7</b>	<b>613.6</b>
Тэмээний ноос	4.7	4.6	0.1	0.1	97.9	-0.1
Хонины ноос	2916.1	3475.5	89.0	89.3	119.2	559.4
Ямааны ноолуур	267.1	299.9	8.1	7.8	112.3	32.8
Бодын хөөвөр	53.6	67.0	1.6	1.7	125.0	13.4
Бодын хялгас	36.2	44.3	1.1	1.2	122.4	8.1
<b>Арьс,мян,шир</b>	<b>232</b>	<b>260.7</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>112.4</b>	<b>28.7</b>
Тэмээ	0.014	0	0.01	-	-	-
Адуу	19.9	14.0	8.6	5.4	70.4	-5.9
Үхэр	21.5	24.4	9.3	9.4	113.5	2.9
Хонь	108.0	130.3	46.6	50.0	120.6	22.3
Ямаа	82.6	92.0	35.6	35.3	111.4	9.4

II.2.1 Мал бүхий өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

**Мал бүхий өрх малчдын тоо.** 2015 онд амины малтай 17.4 мянган өрх, үүний дотор 14.1 мянган малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна.

Малтай өрхийн нийт ам бүлийн тоо 62.5 мянга, малчин өрхийн ам бүлийн тоо 51.8 мянгад хүрч нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 4 байна.

2015 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 26.9 мянган малчид ажиллаж байна. Малчдын 47.7 хувь буюу 12.7 мянга нь эмэгтэй малчид байна.

Насны бүлгээр авч үзвэл 36.4 хувь нь 16-34 насны, 53.9 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах хүртэлх насныхан, 9.7 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Хүснэгт 2

**Өрх, малчдын тоо, насны бүрэлдхүүн**

	2011	2012	2013	2014	2015	2015/2014	
						хувь	зөрүү
<b>Малтай өрх, ( мян )</b>	<b>17.6</b>	<b>17.8</b>	<b>17.1</b>	<b>17.2</b>	<b>17.4</b>	101.1	0.2
<b>Малчин өрх, ( мян )</b>	<b>14.7</b>	<b>14.1</b>	<b>13.7</b>	<b>13.9</b>	<b>14.1</b>	101.4	0.2
<b>Малчдын тоо, ( мян )</b>	<b>28.0</b>	<b>26.1</b>	<b>26.2</b>	<b>26.6</b>	<b>26.9</b>	101.1	0.3
Үүнээс: 16-34 насны	11.4	10.5	10.1	9.8	9.8	100.0	0
35-аас тэтгэвэрт гарах насны	13.5	13.3	13.6	14.2	14.5	102.1	0.3
Тэтгэврийн	3.1	2.3	2.4	2.6	2.5	96.1	-0.1
<b>Нийт малчдаас эмэгтэй</b>	<b>12.3</b>	<b>12.4</b>	<b>12.5</b>	<b>12.6</b>	<b>12.7</b>	100.8	0.1
<b>Насны бүрэлдхүүн %</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>		
Үүнээс: 16-34 насны	40.6	40.2	38.9	36.8	36.4		-0.4
35-аас тэтгэвэрт гарах насны	48.0	51.0	51.9	53.4	53.9		0.5
Тэтгэврийн	11.4	8.8	9.2	9.8	9.7		-0.1
<b>Нэг малчин өрхөд ногдох малын тоо</b>	<b>203</b>	<b>241</b>	<b>275</b>	<b>309</b>	<b>316</b>		7


2015 оны малчин өрхийн тоо 2014 онтой харьцуулахад 0.3 мянгаар, малчдын тоо 0.4 мянгаар нэмэгдсэн байна.

Малчин өрхийн тоо Цэнхэр /57/, Эрдэнэбулган /42/,Өлзийт/41/ Булган /27/,Ихтамир/26/ , Цахир /23/,Хайрхан /19/, /Батцэнгэл/14/,Хотонт/12/ сумдад өсч, бусад сумдад 3-10 -аар буурсан байна.

Малчдын тоог сумдаар авч үзвэл Цэнхэр /95/,Эрдэнэбулган /91/,Өлзийт /60/, Булган /45/, Батцэнгэл /39/, Цахир /35/,Хотонт /31/,Жаргалант /22/ Ихтамир /14/ сумдад өнгөрсөн оныхоос өсч, бусад сумдад 16-31-ээр буурсан байна.

2015 онд 1 малчин өрхөд 316 толгой мал ногдож, 2014 оныхоос 7 толгойгоор өссөн байна. Нэг малчин өрхөд ногдох малын тоо Хашаат /271/,Хотонт /79/,Өлзийт /19/,Цэцэрлэг /11/,Хайрхан /11/,Эрдэнэмандал /8/,Цахир /8/,Булган /5/ толгойгоор өсч,харин бусад сумд 3-33 толгойгоор буурсан байна.( Хавсралт 9,10 ).

Зураг 2




**Малчдын нийгэм ахуйн зарим үзүүлэлт.** 2015 оны тооллогоор нийт малчин өрхийн 91.8 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 77.1 хувь нь телевизортой, 33.0 хувь нь авто машинтай, 46.4 хувь нь мотоциклтэй, 1.2 хувь нь трактортай, 94.5.0 хувь байна.

Сүүлийн 8 жилд хөдөө орон нутагт нарны, салхины цахилгааны эх үүсгэврийн хэрэглээ нэмэгдэж, 2013 оныхоос телевизортой өрхийн тоо 0.8 мянгаар буюу 8.0 хувиар, мотоциклтэй өрхийн тоо 0.7 мянгаар буюу 12,3 хувиар, трактортой өрхийн тоо 18.2 хувиар буюу 25-аар тус тус нэмэгдсэн байна.

	Өрхийн тоо				$\frac{2015}{2014}$ %	Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2012	2013	2014	2015		2012	2013	2014	2014	
Цахилгаантай	11253	12006	12717	12886	105.9	79.5	87.6	91.8	91.4	
Телевизортой	9852	9888	10683	10685	108.0	69.6	72.1	77.1	75.9	
Автомашинтай	3506	2769	3416	3683	123.3	25.0	33.0	33.0	26.2	
Мотоциклтэй	4721	5706	6425	6126	112.6	33.5	41.6	46.4	43.3	
Трактортой	121	137	162	187	118.2	0.9	1.0	1.2	1.4	

Сумаар харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 3-д харуулав.

Зураг 3



Цахилгаан үүсгүүрийн аль төрөл нь малчин өрхийн гол хэрэглээ болж байгааг тодорхойлох зорилгоор 2006 оноос хойш мал тооллогоор цахилгаан үүсгүүрийг төрлөөр задлан авсан.

Хүснэгт 4

**Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо**

	Бүгд	Үүнээс:				Дүнд эзлэх хувь			
		Нарны	Салхины	Бага оврын мотор	Төвлөрсөн	Нарны	Салхины	Бага оврын мотор	Төвлөрсөн
Цахилгаан үүсгүүртэй өрх	12886	12385	212	15	345	96.1	1.5	-	2.7

Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 96.1 хувь нь нарны, 1.5 хувь нь салхины, 2.7 хувь нь төвлөрсөн цахилгаан эх үүсгүүр хэрэглэж байна.

**II.2.2 Мал, тэжээвэр амьтдын тоо, сүргийн бүтэц**

**Малын тоо.** Манай аймгийн малын тоо 2015 оны эцэст 4457.1 мянга болж, 2014 оныхоос 163.9 мянгаар буюу 3.8 хувиар өслөө.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 1.1 мянга, адуу 324.2 мянга, үхэр 544.2 мянга, хонь 2317.0 мянга, ямаа 1270.6 мянгад хүрч, 2014 оныхоос тэмээ 126 толгойгоор, адуу 20.2 мянгаар, үхэр 41.7 мянгаар, хонь 87.5 мянгаар, ямаа 14.6 мянган толгойгоор тус тус өссөн байна. (хавсралт 1,2)

2015 онд 248.7 мянган сарлаг тоологдсон нь нийт үхрийн 45.7 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо 2014 оныхоос 4.8 хувиар буюу 11.3 мянган толгойгоор өсчээ. (Хавсралт 35)

Малын тоо


	Малын тоо					Хүснэгт 5			
	2011	2012	2013	2014	2015	2014	2015	2015/2014	
						2012	2013	хувь	зөрүү
Бүгд	2984.3	3403.2	3772.3	4293.2	4457.1	140.7	118.4	103.8	163.9
Тэмээ	0.9	1.1	1.1	1.2	1.1	122.2	100.0	89.5	-126
Адуу	218.7	238.6	268.2	303.9	324.2	136.8	120.8	106.7	20.2
Үхэр	335.9	371.1	427.2	502.6	544.2	141.5	127.4	108.3	41.7
Хонь	1464.6	1746.8	1944.1	2229.5	2317.0	146.4	119.2	103.9	87.5
Ямаа	964.2	1045.6	1131.8	1256.0	1270.6	132.7	112.3	101.2	14.6

2015 онд нийт малын тоо толгойн 80.5 хувийг бог мал, 12.2 хувийг үхэр, 7.3 хувийг адуу эзэлж байна. Бүх сумдын малын тоо 7.1-27.8 хувиар буюу 7.8-48.2 мянган толгойгоор өсчээ. Өнгөрсөн жил цаг агаар харьцангуй тааламжтай, мал, төлийн хорогдол урьд жилүүдийнхээс бага байсан нь нөлөөлсөн байна.

( Хавсралт 3

Малын тоо

Зураг 4



Эрдэнэмандал (415.3 мянга), Батцэнгэл (324.7 мянга), Хашаат (301.4 мянга) сумд малын тоогоороо аймагт тэргүүлжээ. (Хавсралт 8)


Хүснэгт 6

**Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь**

	2010	2011	2012	2013	2014	2015
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.03	0.03	0.03	0.03	0.02	0.02
Адуу	7.3	7.3	7.0	7.1	7.1	7.3
Үхэр	11.3	11.3	10.9	11.3	11.7	12.2
Хонь	49.5	49.1	51.3	51.5	51.9	52.0
Ямаа	31.77	32.27	30.77	30.07	29.28	28.48


2015 онд аймагт нийт мал болон хонины тоогоор Эрдэнэмандал, адуугаар Батцэнгэл, ямаагаар Хотонт, тэмээгээр Хашаат, үхэрээр Өндөр-улаан сум тэргүүлж байна. (Хавсралт 8).

Зураг 5



2015 онд улсад аймгуудаас Өвөрхангай нийт малын тоогоор \4511.0\,Архангай \үхэр\544.2\,хониороо \2317.0\ Төв адуугаар \360.8\,Өмнөговь тэмээгээр \118.6\ Баянхонгор ямаагаар \2314.4\ тэргүүлж байна. (Хавсралт 51).

Зураг 6



**Хувийн / амины / малын тоо.** 2015 онд хувийн малын тоо 4449.3 мянган толгойд хүрч, нийт малын 99.8 хувийг эзэлж байна. Тэмээний 100.0 хувь, адууны 100.0 хувь, үхрийн 99.9 хувь, хонины 99.8 хувь, ямааны 99.8 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн малын тоо урьд оноос 3.8 хувиар буюу 162.0 мянгаар өсчээ.

( хавсралт 4,5 ).

Хувийн малтай өрх, тэдгээрийн малын тоо

Хүснэгт 7

	Малтай өрхийн тоо Мян,өрх	Бүгд	үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2002	20.8	1738.0	0.7	197.0	252.5	763	524.8
2003	20.0	1828.6	0.7	191.9	230.2	801	604.8
2004	19.3	1939.2	0.6	190.6	231.0	855.8	661.2
2005	18.9	2184.2	0.6	194.0	252.7	984.4	752.5
2006	18.9	2518.0	0.8	204.8	280.6	1153.5	878.3
2007	18.6	2900.6	0.8	219.3	315.6	1349.7	1015.4
2008	18.6	3369.8	0.7	235.8	351.7	1172.2	913.3
2009	18.6	3608.2	0.8	250.8	385.1	1779.0	1192.5
2010	18.5	2674.4	0.9	196.0	301.5	1324.6	851.4
2011	17.6	2979.9	0.9	218.6	335.5	1462.1	962.6
2012	17.8	3397.6	1.1	238.5	370.5	1743.8	1043.7
2013	17.1	3766.9	1.1	268.1	426.6	1941.1	1130.0
2014	17.2	4287.3	1.2	303.8	502.1	2225.9	1254.3
2015	17.4	4449.3	1.1	324.1	543.7	2311.8	1268.6

2015 оны байдлаар хувийн аж ахуйд байгаа малын 28.5 хувийг ямаа, 51.9 хувийг хонь, 7.3 хувийг адуу, 12.3 хувийг үхэр эзэлж байна.

**Өрхийн малын бүлэглэлт**

2015 оны эцэст дэх иргэдийн хувийн малын бүлэглэлтээс авч үзвэл 100 хүртэл толгой малтай өрхийн тоо 5.3 мянга болж, 2014 оныхоос 0.2 мянган өрхөөр буюу 3.0 хувиар багассан нь малын өсөлттэй холбоотой юм. 100 дээш малтай өрхийн тоо 12.0 мянгад хүрч 2014 оныхоос 0.3 мянган өрхөө буюу 2.5 хувиар өссөн байна. 2015 онд нийт малтай өрхөд 100 хүртэл толгой малтай өрхийн эзлэх хувийн жин 30.5 болж, 2014 оныхоос 4.7 пунктээр багасч, харин түүнээс дээшхи бүлгийн малтай өрхийн эзлэх хувийн жин 69.5 хувь болж, 2.2 пунктээр өссөн байна. 2015 оны байдлаар малтай өрхийн 30.5 хувь 100 хүртэл толгой малтай, 25.3 хувь нь 101-200 толгой малтай, 44.2 хувь нь 200-аас дээш толгой малтай байна.

( хавсралт 12 ).

Хүснэгт 8

**Малтай өрхийн малын бүлэглэлт**

Малтай өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Малын тоо, мян,тол
-------------------	-----------------	--------------------

	2014	2015	2014	2015	2014	2015
<b>Дүн</b>	<b>17219</b>	<b>17362</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>4287.3</b>	<b>4457.1</b>
100 хүртэл малтай	5499	5335	32.0	30.5	254.7	260.6
101-200 малтай	4270	4407	25.0	25.3	627.4	649.2
201-500 малтай	5318	5387	30.8	31.0	1672.4	1697.3
501-999 малтай	1638	1634	9.3	9.2	1097.2	1094.6
1000-1499 малтай	405	500	2.3	2.9	461.1	561.7
1500-2000 малтай	58	62	0.3	0.6	98.2	104.5
2001-ээс дээш малтай	31	37	0.3	0.2	76.3	89.2

1000-аас дээш малтай өрх 594 өрх тоологдсон бөгөөд 2014 оныхоос 100 өрхөөр нэмэгдсэн байна. Хамгийн олон малтай өрхөөр Хайрхан сумын өрх орж байна.

1000-аас дээш малтай өрхийн тоогоор Эрдэнэмандал сум тэргүүлж, удаахь байранд Батцэнгэл, Хашаат, Хайрхан сумд орж байна.  
(Хавсралт 13).

2015 оны байдлаар амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй болсон малчин өрхийн эзэмшилд нийт малын 99.8 хувь буюу 4449.3 мянган толгой мал байна. (Хүснэгт 14).

### Малчин өрхийн малын бүлэглэлт

Хүснэгт 9

	Малчин өрхийн тоо		Малын тоо, мян,тол		үүнээс:				
	2014	2015	2014	2015	ТЭМ ээ	адуу	үхэр	хонь	ямаа
<b>Дүн</b>	13858	14126	3906.2	4069.5	1.0	295.9	482.2	2131.7	1158.5
100 хүртэл малтай	3467	3415	173.8	172.5		15.2	46.8	55.3	54.9
101-200 малтай	3492	3636	517.5	539.2		43.3	92.7	223.3	179.9
201-500 малтай	4837	4913	1531.7	1557.6	0.1	111.8	184.4	779.8	481.5
501-999 малтай	1577	1565	1058.2	1050.6	0.8	71.7	94.7	606.9	276.6
1000-1499 малтай	396	495	450.5	555.9	0.1	36.5	46.2	344.5	128.6
1500-2000 малтай	58	62	98.2	104.5		9.2	9.4	66.9	19.0
2001-ээс дээш малтай	31	37	76.3	89.2		8.2	8.0	55.0	18.0

2014 оны байдлаар малчин нэг өрхөд дунджаар 281 толгой мал, үүний дотор адуу 20,үхэр 32, тэмээ 1, хонь 147, ямаа 82 тус тус ногдож байсан бол 2015 онд дунджаар 281 толгой мал ногдож, үүний дотор адуу 20, үхэр 32, тэмээ 1, хонь 147, ямаа 82 ногдож байна. 2014 онд малчин нэг өрхөд ногдох малын тоо дунджаар өмнөх оныхоос 32 толгойгоор нэмэгдсэн байна.

Аймгийн дунджаар малтай нэг өрхөд 251 толгой мал ногдож байгаа нь 2013 оныхоос 31 толгой малаар нэмэгдсэн байна. Малтай нэг өрхөд ,адуу 18, үхэр 29, хонь 130, ямаа 73 ногдож байна.

1 өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 80.9 хувь нь бог мал, 19.1 хувь нь бод мал байна.

Мал бүхий өрхийн дүнд дийлэнх хувийг эзэлж байгаа 200 хүртэл толгой малтай нэг өрхөд дунджаар 92 толгой, 201-999 малтай нэг өрхөд 346 толгой, 1000 ба түүнээс дээш малтай өрхөд 1275 толгой мал тус тус ногдож байна.

Хүснэгт 10

<b>Малтай 1 өрхөд ногдох хувийн малын тоо, бүлэглэлтээр</b>								
	2013	2014	2015					
			Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
<b>Дүн</b>	<b>220</b>	<b>251</b>	<b>258</b>	<b>1</b>	<b>19</b>	<b>31</b>	<b>132</b>	<b>75</b>
10 хүртэл малтай	6	6	6		1	3	1	1
11-30 хүртэл малтай	20	21	21		2	7	6	6
31-50 хүртэл малтай	41	41	39		4	11	12	12
51-100 хүртэл малтай	74	74	77		7	18	28	24
101-200 малтай	146	146	153		12	26	62	53
201-500 малтай	310	315	325		24	37	163	101
501-999 малтай	676	686	693	1	48	58	403	183
1000-1499 малтай	1141	1153	1158		76	99	718	265
1500-2000 малтай	1706	1692	1695		130	147	1052	366
2001-ээс дээш малтай	2470	2460	2465	1	212	220	1553	479

Малтай өрхөд ногдох малын тоо урд оноосоо Эрдэнэмандал,Цэцэрлэг сумаас бүх сумдад 7-65 толгойгоор өссөн байна. (Хавсралт 6).

**Хээлтэгч мал.** 2015 оны эцэст 1905.8 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 63.8 мянган толгойгоор өсч үүний дотор гүү 6.8 мянгаар, үнээ 16.7 мянгаар, эм хонь 33.1 мянгаар, эм ямаа 7.1 мянгангаар,ингэ 20 толгойгоор өссөн байна.

(Хавсралт 17).

Хүснэгт 11

**Хээлтэгч малын тоо**

						Мян.тол
						2015/2014

	2011	2012	2013	2014	2015	хувь	Зөрүү
Бүгд	1285.9	1461.1	1617.4	1842	1905.8	103.5	63.8
Ингэ,тол	0.3	0.4	0.4	0.4	0.4	103.0	20
Гүү	66.9	73.0	82.4	91.9	98.7	107.4	6.8
Үнээ	132.4	143.8	162.9	188.8	205.5	108.8	16.7
Эм хонь	665.3	786.2	872.0	1008.9	1042.1	103.3	33.1
Эм ямаа	421.0	457.7	499.7	552.0	559.1	101.3	7.1

Хээлтэгч мал нийт малын 42.8 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 38.3 хувь, адуун сүргийн 30.5 хувь, үхэр сүргийн 37.8 хувь, хонин сүргийн 45.1, ямаан сүргийн 44.1 хувийг тус тус эзэлж байна.

Булган,Батцэнгэл,Цэцэрлэг,Хайрхан,Эрдэнэмандал сумд хээлтэгч малын тоо 2.5-3.3 хувиар буюу 1,0-4,2 мянган толгойгоор буурч,харин бусад сумдын 1,4-10,1 хувиар буюу 1,5-10,4 мянган толгойгоор өссөн байна.  
(Хавсралт 17).

Зураг 7



Эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад бод малын хувьд хээлтэгч мал сүргийн 50.0-55.0 хувь, бог малын хувьд сүргийн 60.0-65.0 хувийг эзэлж байвал зохимжтой гэж үздэг байна. Сүүлийн 7 жилийн байдлаар сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 44.6 хувь, бог малд 35.0 хувь байна.

**Төл бойжилт.** 2015 онд гарсан төлийн 93.7 хувь буюу 1629.5 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2014 оныхоос 207.9 мянган толгойгоор өсчээ. Ботгоны 98.1 хувь, унаганы 94.2 хувь, тугалны 95.2 хувь хурганы 90.0 хувь, ишигний 88.5 хувь бойжуулсан байна.

Хүснэгт 12

**Төл бойжилт**

	Бүгд			үүнээс				
	2013	2014	2015	ботго	унага	тугал	хурга	Ишиг
Гарсан төл	1331.1	1421.6	1629.5	0.3	76.7	162.6	907.3	482.6
Бойжсон төл	1270.2	1374.0	1526.6	0.3	72.3	155.6	863.8	434.6
Бойжилтийн	95.4	96.6	93.7	98.1	94.2	95.7	95.2	90.0
Хувь								

Бойжуулсан төлийн тоо урьд оноосоо Булган,Цэцэрлэг сумд 6.3-11.1 хувиар буурч, бусад сумд 1.5-34.5 хувиар өссөн байна.  
(Хавсралт 19).

Бойжуулсан төлийн тоо 2014 оноосоо тугал 28.9 мянгаар, унага 10.7 мянгаар,ботго 0.1мянгаар ,хурга 100.2 мянгаар, ишиг 12.7 мянгаар өссөн байна.

Хүснэгт 13

**Бойжуулсан төл**

	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Бүгд	1142.1	283.6	934.8	1105.3	1270.2	1374.0	1526.6
Ботго	0.1	0.1	0.1	0.2	0.2	0.2	0.3
Унага	51.8	25.2	43.9	52.1	58.9	61.6	72.3
Тугал	98.3	64.1	90.5	101.8	118.2	126.7	155.6
Хурга	598.9	340.7	495.7	591.4	694.5	763.6	863.8
Ишиг	393.0	153.4	304.4	359.8	398.4	421.9	434.6

Аймгийн дунджаар 100 эхээс 83 төл бойжуулж, 100 эхээс бойжуулсан төлийн тоо 2014 оныхоос унага,тугал,ботго төрөл дээрээ өсч,хурга,ишиг буурсан байна. Бүх сумдын 100 эхээс бойжуулсан төлийн тоо урьд оноосоо Өгийнуур\6\,Өлзийт \9\,Чулуут \9\,Тариат \14\ өсч, харин бусад сумд 3-30 толгойгоор буурсан байна.  
( Хавсралт 20 ).

Зураг 8



**Том малын зүй бусын хорогдол.** 2015 онд оны эхний нийт малын 2.3 хувь нь буюу 100.3 мянган толгой мал хорогдсон нь 2014 оныхоос 6.2 мянгаар буюу 6.2 хувиар буурсан байна.

Нийт хорогдсон малын 30.7 хувийг ямаа, 52.2 хувийг хонь, 9.2 хувийг үхэр, 6.3 хувийг адуу эзэлж байна.

Хүснэгт 15

**Том малын зүй бус хорогдол**

	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Бүгд	56.7	1084.2	88.3	59.7	196.1	94.1	100.3
Тэмээ	-	-	-	-	-	-	-
Адуу	4.1	70.7	3.2	3.2	12.3	9.1	6.6
Үхэр	4.6	126.4	8.5	9.3	18.1	11.3	10.5
Хонь	21.5	499.9	47.8	27.7	105.2	41.5	52.4
Ямаа	26.4	387.2	28.8	19.5	60.5	32.2	30.8

Нийт хорогдсон малын 7.7 мянга нь өвчнөөр хорогдож, хээлтэгч мал 26.5 мянга хорогдсон байна. Урьд оноосоо хээлтэгч малын хорогдол 5.3 мянгаар буюу 25.0 хувиар нэмэгдсэн байна.

( Хавсралт 21 ).

Зураг 9



**Оны эхний малд эзлэх хувь**

	2010	2011	2012	2013	2014	2015
Бүгд	40.5	3.3	2.0	5.8	2.5	2.3
Тэмээ	3.1	0.3	0.0	0.8	0.8	0.2
Адуу	36.0	1.6	1.5	5.2	3.4	2.2
Үхэр	41.9	2.8	2.8	4.9	2.6	2.1
Хонь	37.7	3.6	1.9	6.0	2.1	2.4
Ямаа	45.4	3.4	2.0	5.8	2.8	2.5

**Малын хээл, хаялт, сувайралт.** 2015 онд оны эхний хээлтэгч малын 11.3 хувь буюу 208.8 мянган мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 2014 оныхоос 25.2 хувиар буюу 11.0 мянгаар нэмэгдсэн байна. Төл өгөөгүй хээлтэгч малын 67.9 хувь буюу 67.0 мянга нь сувайрсан хээлтэгч, 32.1 хувь буюу 67.0 мянга нь хээл хаясан хээлтэгч байна.  
(Хавсралт 22,23, 24)

**Хээл хаяж, сувайрсан эх малын тоо**

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2013	2014	2015	2013	2014	2015	2013	2014	2015
Бүгд	164.4	197.8	208.8	115.7	143.3	141.8	48.7	55.3	67.0
Ингэ	-	0.1	-	-	0.1	-	-	-	-
Гүү	11.7	14.7	14.4	8.6	11.7	11.0	2.9	3.7	3.4
Үнээ	21.1	28.6	28.3	15.6	20.7	20.2	5.5	7.9	8.1
Эм хонь	75.2	88.8	90.8	53.9	65.4	63.6	21.5	23.4	27.2
Эм ямаа	56.4	65.6	75.3	37.6	45.5	47.0	18.8	20.3	28.3

Сумаар авч үзвэл хээл хаясан малын тоо Тариат, Батцэнгэл,Өгийнуур, Эрдэнэмандал,Өндөр-улаан,Хашаат,Чулуут сумд 5-30 толгойгоор багасч, бусад сумдын мал 18-4574 толгойгоор нэмэгджээ.

Мөн сувайрсан малын тоо 2013 оныхоос Хайрхан,Цэнхэр,Жаргалант,Тариат,Өндөр-улаан,Хотонт,Өлзийт,Цэцэрлэг сумд 399-4177 толгойгоор нэмэгдэж, бусад сумд 24-5338 толгойгоор нэмэгдсэн байна.

**Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь**

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2013	2014	2015	2013	2014	2015	2013	2014	2015
Бүгд	11.3	12.2	11.3	7.9	8.9	7.7	3.3	3.4	3.6
Ингэ	-	17.7	-	-	17.7	1.7	-	-	0.2
Гүү	16.0	17.8	15.7	11.8	14.2	12.0	4.0	4.5	3.7
Үнээ	14.7	17.5	15.0	10.8	12.7	10.7	3.8	4.9	4.3
Эм хонь	9.6	10.2	9.0	6.9	7.5	6.3	2.7	2.7	2.7
Эм ямаа	12.3	13.1	13.6	8.2	9.1	8.5	4.1	4.1	5.1

Төл өгөөгүй хээлтэгч малын 79.6 хувийг бог мал, 20.4 хувийн бод мал эзэлж байна.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна.

2015 онд 37.4 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2014 оныхоос 1.6 хувиар буюу 0.5 мянгаар өссөн байна. Азарганы тоо 0.6 мянгаар, бухны тоо 0.3 мянгаар, хуцны тоо 1.7 мянгаар, ухны тоо 0.1 мянгаар нэмэгдэж, буурны тоо 3-аар өмнөх оноосоо буурсан байна.

**Хээлтүүлэгч малын тоо**

	Хээлтүүлэгч мал - бүгд					үүнээс: шинээр тавьсан				
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Бүгд	25615	30473	32286	36876	37413	32	76	60	60	124
Буур	15	17	16	17	14	-	-	-	-	-
Азарга	7788	8226	8782	9587	10224	18	16	17	13	19
Бух	4889	5485	6275	7466	7773	12	27	32	47	19
Хуц	7673	10120	10326	12050	11992			18		57
Ухна	5250	6642	6887	7756	7410		7	9		29

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад 2015 онд аймгийн дунджаар нэг хуцанд 87 эм хонь, нэг ухнад 75 эм ямаа ногдож, 2.6-3.1 дахин өндөр үзүүлэлт гарч байна.  
( Хавсралт 25 ).

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо**

	Үржлийн Норм	2010	2011	2012	2013	2014	2015
Ингэ	20-25	16	17	24	24	24	28
Гүү	12 15	9	8	9	9	10	10
Үнээ	35-45	29	25	26	26	25	26
Эм хонь	25-30	100	84	78	84	84	87
Эм ямаа	25-30	100	78	69	73	71	75

**Малын хэрэглээний зарлага.** 2015 онд оны эхний нийт малын 29.6 хувь буюу 1270.2 мянган малыг хэрэглээнд зарцуулсны үхэр 104.1 мянга, адуу 45.5 мянга, хонь 729.1 мянга, ямаа 391.1 мянгыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малтай нэг өрх дунджаар 47 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан байна. Үүнийг аймгийн хэмжээний нийт өрхөд оногдуулбал нэг өрхөд дунджаар 30 мал буюу 2 бод, 29 богийг хэрэглээндээ зарцуулсан байна.  
( Хавсралт 26,27 ).

**Малын хэрэглээний зарлага**

	2011	2012	2013	2014	2015
Бүгд	541.4	713.6	713.6	756.0	1270.2
Тэмээ				0.1	0.4
Адуу	18.2	29.1	18.3	16.8	45.5
Үхэр	48.0	57.3	46.7	40.0	104.1
Хонь	310.8	281.4	394.9	436.7	729.1
Ямаа	164.4	258.9	253.5	265.4	391.1
Оны эхний малд эзлэх хувь					
Бүгд	20.2	21.0	21.0	20.1	29.6
Тэмээ			15.0	11.3	31.5
Адуу	9.3	13.3	7.7	6.3	15.0
Үхэр	15.9	17.1	12.6	9.4	20.7
Хонь	23.4	19.2	22.6	22.5	32.7
Ямаа	19.3	26.8	24.2	23.4	31.1

Хэрэглээнд зарцуулсан малын 92.9 хувийг бог мал, 7.1 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхний адууны 6.3 хувь, үхрийн 9.4 хувь, хонины 22.5 хувь, ямааны 23.4 хувийг хэрэглээнд зарцуулсан байна.

**Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод  
хэрэглэсэн малын тоо**

	Зах зээлд худалдан борлуулсан					Хүнсэнд хэрэглэсэн				
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Бүгд	344.7	340.1	401.1	384.0	489.7	193.2	164.4	161.0	165.8	178.0
Тэмээ				0.1	0.1					-
Адуу	14.8	16.8	21.0	17.4	21.4	10.9	9.3	9.2	8.3	15.5
Үхэр	28.4	31.3	36.7	33.0	38.5	20.1	17.2	15.9	15.5	15.8
Хонь	209.3	191.4	71.9	211.4	279.1	102.6	78.8	27.8	80.5	87.1
Ямаа	92.2	100.6	144.4	122.1	150.6	59.6	59.1	64.0	61.5	66.6

Хэрэглээнд зарцуулсан малын 73.4 хувийг зах зээлд худалдан борлуулж, 26.6 хувийг хүнсэнд зарцуулсан байна.

Малтай нэг өрх дунджаар 31 толгой малыг зах зээлд борлуулж, 12 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

Зураг 10



**Сүргийн бүтэц.** 2015 оны байдлаар нийт сүргийн 34.8 хувь буюу 1544.9 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 21.6 хувь буюу 962.1 мянган толгой нь нас гүйцсэн

мал, 42.8 хувь буюу 1905.8 мянган толгой нь хээлтэгч мал, 0.8 хувь буюу 37.4 мянга нь хээлтүүлэгч мал байна. ( Хавсралт 29-34 ).

Хүснэгт 23

**2015 оны сүргийн бүтэц**

	Толгойгоор, мян,тол					Хувиар				
	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	хээлтэгч	Хээлтүүлэгч	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч
Бүгд	4457.1	1544.9	962.0	1905.8	37.4	100.0	34.8	21.6	42.8	0.8
Тэмээ										
Толгой	1.1	0.5	0.2	0.4	-	100.0	42.5	17.9	38.3	1.3
Адуу	324.1	142.7	72.5	98.7	0.2	100.0	44.0	22.4	30.5	3.2
Үхэр	544.2	233.6	97.3	205.5	7.8	100.0	42.9	17.9	37.8	1.4
Хонь	2317.0	783.5	479.4	1042.1	12.0	100.0	33.8	20.7	45.0	0.5
Ямаа	1270.6	384.6	312.6	559.0	7.4	100.0	30.3	24.6	44.0	0.6

Хүснэгт 24

**Сүргийн бүтэц, хувиар**


	Төл, өсвөр насны					Нас гүйцсэн эр				
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Бүгд	35.1	34.0	34.9	34.1	34.8	27.4	21.5	22.2	22.1	21.6
Тэмээ	37.0	38.6	32.0	49.1	42.5	42.7	30.3	22.0	16.2	17.9
Адуу	39.2	41.3	42.9	44.1	44.0	40.5	26.6	24.7	22.5	22.4
Үхэр	42.6	43.2	44.2	43.7	42.9	20.0	16.5	16.6	17.3	17.9
Хонь	20.5	22.1	33.8	32.6	33.8	25.3	33.6	32.3	21.6	20.7
Ямаа	31.2	31.7	31.5	30.6	30.3	33.4	24.6	23.9	24.9	24.7

Үргэлжлэл

	Хээлтэгч					Хээлтүүлэгч				
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Бүгд	42.5	42.9	42.9	42.9	42.8	0.9	0.9	0.9	0.9	0.8
Тэмээ	31.1	37.8	35.1	33.3	38.3	1.7	1.6	1.6	1.4	1.3
Адуу	30.6	30.6	30.7	30.2	30.5	3.6	3.4	3.3	3.2	3.2
Үхэр	39.4	38.8	38.1	37.6	37.8	1.5	1.5	1.5	1.5	1.4
Хонь	45.4	45.0	44.8	45.3	45.0	0.5	0.6	0.5	0.5	0.5
Ямаа	43.7	43.8	44.2	43.9	44.2	0.5	0.6	0.6	0.6	0.8

Төл, өсвөр насны малын нийт сүрэгт эзлэх хувийн жин 2014 онтой харьцуулахад нас гүйцсэн малынх тэмээнээс бусад бүх төрөл дээр өсч, хээлтэгч, хээлтүүдэгч бүх төрөл дээрээ буурсан байна.

Зураг 11



**Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.** 2015 оны эцэст цэвэр үүлдрийн 9.6 мянган мал тоологдов.

2014 онтой харьцуулахад цэвэр үүлдрийн үхэр -0.1 мянган толгойгоор буурч, хонь 3.3 мянгаар өссөн байна.

Хүснэгт 25

**Цэвэр болон эрлийз нутгийн шилдэг омгийн малын тоо**

	2012	2013	2013	2014	2015	2015/2014	
						Хувь	зөрүү
Цэвэр үүлдрийн мал							
Үхэр	0.4	0.4	0.9	0.7	0.6	85.7	-0.1
Хонь	3.8	4.3	6.8	6.3	9.0	142.6	3.3
Дүн	4.2	4.7	7.7	7.0	9.6	137.1	3.2

### III.2.3 МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ,ХАНГАМЖ

**Бэлчээрийн хүрэлцээ.** Манай аймгийн Газрын албаны 2015 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар бэлчээрийн хадлангийн талбай 3744.1 мянган га талбайтай байна.


2015 онд 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 247 толгой мал ногдож байна.

Хүснэгт 26

#### Бэлчээрийн хүрэлцээ хангамж

	2011	2012	2013	2013	2015	2015/2014	
						хувь	зөрүү
Хадлан бэлчээрийн талбай мян,га	3744.2	3744.2	3744.1	3744.1	3744.1	100.0	-
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд Шилжүүлсэн малын тоо	141	157	198	227	247	100.9	20

100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 2014 оныхоос 20 толгойгоор нэмэгдсэн байна. ( Хавсралт 37 ).



**Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж.** 2015 онд аймгийн хэмжээгээр тэжээлийн нэгжид шилжүүлснээр 35.5 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь 2014 оныхоос 8.0 хувиар буюу 3.1 мянган тонноор бага бэлтгэсэн байна. (Хавсралт 38,39)


Хүснэгт 27

**Бэлтгэсэн тэжээл, нэр төрлөөр**

	2011	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2014}$ %
Байгалийн хадлан	85139	82525.4	75363.0	81299.8	71830.0	88.3
Гар тэжээл	1191.7	1308.5	1660.0	1445.2	1541.0	106.6
Тэжээлийн ургамал	3576.0	4818.0	1842.5	2337.0	4532.5	193.9
Хужир шүү	142.4	863.0	495.1	214.0	86.2	40.3
Үйлдвэрлэсэн тэжээл						
Бүгд (тэжээл нэгж)	39651.7	39342.7	39089.0	38584.1	35537.1	92.0

Бэлтгэвэл зохих хадлангаа Хотонт, Өгийнуур, Эрдэнэбулган сумд 0.5-4.5 хувиар биелүүлээгүй, бусад бүх сумд 0.4-91.2 хувиар биелүүлээгүй байна.

Зураг 13



#### II.2.4 ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2015 онд 353 гахай, 136 шувуу тоологдсон нь 2014 оныхоос 18 гахай , шувуу 13 толгойгоор ,гахайтай өрхийн тоо 11-ээр , шувуутай өрхийн тоо 2-оор буурсан байна. ( Хавсралт 40 ).

Хүснэгт 28

#### Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо

	2010	2011	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2014} \%$
Гахай	158	141	283	465	371	353	79.8
Шувуу	893	780	95	151	149	136	98.7
Гахайтай өрхийн Тоо	11	16	35	57	56	45	98.2
Шувуутай өрхийн Тоо	3	5	4	7	5	3	71.4

2015 онд тэжээвэр амьтад өсгөн үржүүлдэг өрх 4.1 мянган тонн гахайн мах бэлтгэж 2430.0 мянган төгрөгийн, 0.5 мянган ширхэг өндөг бэлтгэж, 16.1 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна.

## II.2.5 ХУДАГ,УСАН САНГИЙН ТООЛЛОГО

**Худаг,усан сан.** ҮСХ-оос хашаа, худаг уст цэгийн тооллогыг 3 жил тутамд мал тооллоготой хамтруулан явуулж байна. 2015 оны мал тооллоготой хамтруулан худаг, усан сангийн тооллогыг явуулж үр дүнг нэгтгэн гаргалаа.

2015 онд нийт 665 ширхэг худаг, 5 ширхэг усан сан тоологдлоо.

Тоологдсон худгийн 574 ширхэг нь инженерийн хийцтэй, 91 ширхэг нь энгийн худаг байна. Нийт худгаас 249 ширхэг буюу 43.4 хувь нь малын бэлчээрт байршиж байна. ( Хавсралт 41 ).

Хүснэгт 29

Худаг,усан сангийн тоо				
	2006	2009	2012	2015
<b>Худаг-бүгд</b>	1088	963	436	665
үүнээс:				
Инженерийн	940	476	322	574
Энгийн	148	487	114	91
Бэлчээрт байршдаг	631	540	315	249
Ашиглагддаггүй	389	303	41	23
<b>Усан сан</b>	17	11	5	5
Багтаамж	37.4	26.0	12.0	12.0

## II.2.6 Шинээр гаргасан, засварласан худаг

